

ХҮННҮГИЙН ДАРАА ҮЕИЙН УГСААТНЫ ҮЙЛ ЯВЦЫН ЗАРИМ АСУУДАЛД

С.ӨЛЗИЙБАЯР

Товч агуулга: Монголчуудын угсаа гарвалын түүхэн үйл явцыг Хүннүтэй холбон тайлбарлах оролдлогыг бид хийсээр ирсэн бөгөөд дон жилүүд улирах тусам судалгааны арга улам гүнзгийрэн олон талын амжилт олсоор байгааг дурдууштай. Гэтэл Хүннү судлал хөгжсөн гадаадын бусад орнуудад Дунхугийн бүлгээс монголчуудын гарал үүслийг холбон тайлбарлах хандлага илүү газар авчээ. Бид энэ удаад Хүннү, Дунхугийн бүлгийн нүүдэлчдийн үр хойчис хэн хэн нь монголчуудын угсаа, соёлын үйл явцад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн тухай үзэл баримтлалд зарим нэгэн санал нэмэрлэх оролдлого хийсэн болно. Асуудлын гол зангилаа Жужаны хаант улсын үед тавигдсан бөгөөд төрийн эрх мэдэл Дунхугийн удам (Мугулюйн угсаа)-аас Хүннүгийн үр удмын дэмжлэгийг илүү хүлээсэн талд шилжсэн бололтой. Энэ үйл явц Татар хааны удирдлага дор өрнөсөн батүүнийг дэмжигч хүннү гаралт аймгууд хожмоо “Татар” нэрээр алдарших болсон угсаатны цөмийг бүрдүүлсэн байх талтай. Тэдэнд дийлдсэн монголчууд “Эргүнэ кун”-д шурган хэсэг хутацаанд Ази-Европын тал хээрийн түүхэн үйл явцын өрнөлөөс холуур байсны эцэст Бөртэ-Чинойгоор ахлуулан Онон мөрний хөндий даган өгсөж, Бурхан халдун уулнаа иржээ. Монголчуудын голомтоо бадраасан нутгийг дараа үеийнхэн “Ихэсийн газар” хэмээн тахилга өргөх болсон нь эдүгээ цагт уламжлагдаад буй газар усны эзний буюу “овоо” тахилгын эхлэл болсон бололтой.

Түлхүүр үг: Хүннү-татар, дунху-монгол, жужан, бурхотуйн соёл, шивэй, монгол, Ихэсийн газар, овоо тахилга.

Татар-Монгол

Эдүгээ цагийн монголчуудын угсаа гарвалын түүхэнд шийдэгдээгүй цөөнгүй асуудлууд байгаа нь бичгийн хэлний мэдээ, тухайн цагийн нүүдэлчдийн үлдээсэн биет дурсгал зэрэг сурвалж хэрэглэгдэхүүнийг олон өнцгөөр тайлбарлах, янз бүрийн үзэл баримтлалууд урган гарахад хүргэж байна. Судлаачид монголчуудын

гарал үүслийн түүхийг он цагийн ихээхэн өргөн хүрээнд авч хэлэлцдэг боловч бүхэлд нь хураангуйлан үзвэл “эртний монголчуудын үе” ба “язгуур монголчуудын түүхийн эхний шат”¹ болно. Уг үечлэлийн эхнийх нь Судрын чуулганд дурдсан “Татарын үе” буюу нэн эртнээс монгол нэр түгэх хүртэл, дараагийн шат нь мөн сурвалжийн “Монголын үе” буюу Алан-Гоа-ийн үеэс эхлэн нэртэй сүртэй болсон тул бусад аймгууд цөм монгол аймаг мэтээр алдарших болсон үетэй үндсэндээ тохирно. Татар, монгол нэр нь хоёул Жужаны засаглалын үед бий болж, улмаар угсаатны нэр болж төлөвших үйл явц эхэлсэн бололтой байгаа нь судлаачдын бүтээлээс тодорхой харагдахуйц байна. Тухайлбал, Сун улсын бичигт “жуйжуй, нөгөө нэр нь датань эсвэл таньтань, мөн л хүннүгийн тусгай салаа мөчир” гэх буюу Лян улсын түүхэнд “жуйжуйчуудын эзмшил нь хүннүгийн тусгай салбарын л хэрийнх байх. Вэй, Цзинь улсын үед хүннүчүүд тус бүртээ өөрийн гэсэн нэршил бүхий хэдэн зуу, мянгад хүрэхээр нүүдлийн нэгжүүдтэй (хүрээ С.Ө). Эдгээрийн нэг нь жуйжуй даруй мөн болно. Юань Вэй улс өмнө зүгт нүүдэллэсэний дараа тэдний байсан нутгийг жуйжуйчууд эзлэн авчээ. Тэдэнд дотор, гадуур хана бүхий хот байхгүй, тэд өвс, ус хөөж нэгээс нөгөөд шилжин мал хариулдаг. Сууц нь бөмбөгөр маягийн овоохой”² гэж тэмдэглэн үлдээжээ. Жужаны нөгөө нэр болох “датань” эсвэл “таньтань” мөн хожмын IX зууны сурвалжид нэр гарсан “дада” хэмээх аймгуудын нэрийг “татар” гэж сэргээж, улмаар Жужан улс мөхсний хойно 200 орчим жил өнгөрөөд 732, 735 онд “отуз татар”, “тогуз татар” гэж түрэг бичээсэнд дурдагдсан угсаатан мөн гэж олон судлаачид үзэж байна³. Хятад сурвалжид дурдагдсан нэрийн хамаарлын талаар эсрэг санал гаргасан Ван Говэй, П.Пеллио нар яагаад датань, таньтань, дада нарыг нэг биш гэж үзсэн шалтгааныг манай зарим судлаачид нягтлан үзэх оролдлого хийжээ. Б.Батсүрэн эдгээр утга үсгийн дуудлагыг хэрхэн төсөөлж сэргээж байсныг харьцуулан жишиж үзсэний үр дүнд “...ойлгомжгүй байна” хэмээн үндэслэл муутай болохыг харуулжээ⁴. Судлаачдын дүгнэлтээс үзэхэд жужаны нөгөө нэр болох датань/ таньтань түрэг

¹ Сүхбаатар Г. *Монголын түүхийн дээж бичиг*. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар: 1992, 51.

² *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Введение, перевод и комментарии В.С. Таскина. М., 1984. Стр. 288, 289-290.

³ Сүхбаатар Г. *Монгол нирун улс* (330-555). Улаанбаатар: 1992 нэг сэдэвт зохиолын 182-р талд Г.Учида, Сүрбадрах зэрэг эрдэмтдийг дурдсан байна., Кляшторный С.Г., Савинов Д.Г. Степные империи древней Евразии (Исторические исследования). СПб, 2005. стр.57., Билэгт Л. Татары и Монголы // *SA*.Tom. XVI, Fasc.10. 1996, Дэлгэржаргал П. Монголчуудын угсаа гарвал. Улаанбаатар: 2005, 147; Батсүрэн Б. *VI-X зууны монгол аймгууд (Түүх-угсаа гарвалын шинжилгээ)*. Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилох бүтээл. Улаанбаатар: 2012, 62.

⁴ Батсүрэн Б. *VI-X зууны монгол аймгууд (Түүх-угсаа гарвалын шинжилгээ)*. Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилох бүтээл. Улаанбаатар: 2012. Хүснэг 2. т. 51.

бичээсэнд дурдагдсан “татар” мөн болох нь эргэлзээгүй байна. Харин уул нэр 414-429 онд төр барьж байсан Жужаны Датань хааны нэрнээс үүдэлтэй болох талаар судлаачид бараг нэгдмэл саналд хүрээд байгаа талаар үгүүлэх ёстой. Жаруны бага авга ах Пухуний хүү Датань хаан ширээнд суусан үйл явц нь жам ёсны хэрэг байгаагүй бөгөөд Жарун хааны таалал болсны хойно түүний үрс болон авга талын төрлийнхний хуйвалдааны дүн болно. Тиймээс ч Датань хаан Жужаны хааны шууд угсаа бус, авгын талын хүн болохоор хааны угсааны нирунаймагт хамаардаггүй учир нирун аймагт татарчууд багтдаггүй гэж Г.Сүхбаатар дүгнэжээ⁵. Татар хаан нь Жужаны хаан ширээ залгамжлалыг өөрчлөн өөрийн угсаагаар сольсон нь ийнхүү хожмоо ихэд алдаршсан угсаатны нэрийг бий болоход хүргэжээ. Датань хааны дараахан буюу 420-478 онд оршиж асан өмнөдийн Сун улсын бичигт бидний өмнө үгүүлсэн жуйжуйг бас датань/ таньтань гэх хоёр янзаар нэрлэдэг талаар дурдсан нь санаандгүй хэрэг бус бололтой. Өөрөөр хэлбэл, Жужаны угсаа залгамжлалаас Татарынхад шилжсэн учраас ийнхүү нэрлэхэд хүргэсэн байх боломжтой бөгөөд угсаа залгамжлалаар тухайн харъяатныг нэрлэх түгээмэл үзэгдлийн хүрээнд ийнхүү нэрлэгджээ. Мөн хятад хоёр сурвалж бичигт тэднийг хүннүгийн салбар аймаг гэж шууд цохон дурдсаныг дахин үгүүлсүгэй. Нөгөө талаар дунхугийн бүлгийн аймгуудын дунд татар нэр байхгүй, харин “жуаньжуань дунхугийн удам, овгийн нэр Юйцзюлюй” гэж Вэй улсын түүхэнд тэмдэглэгджээ⁶. Эндээс жужан дунхугийн удам мөн бол хүннүгийн салбар аймаг нь жужанаас илүү татарт хамааралтай байх логик дүгнэлт гарч байна. Датань хаан ширээ залгамжлах болсноор Жужаны нийгэмд дунху бүлгийн өвөг монгол угсаанаас хүннү гарвалт өвөг монголчууд ноёлох байр суурьтай болсон гэж бид үзэж байна. Өөрөөр хэлбэл, хүннү гаралт аймгуудыг Жужаны хааны удмын (юйцзюлюй ураг) Датань захирч байсан учраас хүннүгийн хойчис ийнхүү өндийх нөхцөл бүрдсэн бололтой. Эрт цагтаа нэгдмэл байгаад илүү нүүдлийн хэв маяг давамгайлах тусам хүннү, дунху болж салаад “...Хүннүгийн бүлэг нь Дорнод ху, баруун хөрш жун, ди бусадтай удаан хугацааны туршид харилцсаны үндсэн дээр боловсорчээ. Энэхүү үйл явц нь Умард Хятадын археологид тусгалаа олсныг “Ордосын хүрэл” гэж нэрлэгдэх болсон Ляонин, Шаньси, Шэньси, Нинься, Ганьсу мужийн нутгаар тархсан чжоу, чуньцийн үеийн оршуулгын цогцолборууд харуулах”⁷ тул хүннү, дунхуг нэгэн

⁵ Сүхбаатар Г. *Монгол нирун улс* (330-555). Улаанбаатар: 1992, 182

⁶ *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Введение, перевод и комментарии В.С. Таскина. М., 1984. стр. 267.

⁷ Коновалов П.Б. Еще раз о Хуннской ветви этногенеза в Центральной Азии. - *Хүннүгийн эзэнт улс ба Монголын эртний түүхийн судалгаа*. Улаанбаатар: 2012, 18-30.

угтай гэж үзэх нь зүйтэй болно. Ингэж Жужаны нийгэмд хүннү нарын үлдэц байж болох аймгууд Татар хааны захиргаан дор нөлөөгөө тэлэн бэхжих болсон бол дунхугийн удам жужан (Г.Сүхбаатарынхаар Нирун монгол) нарын эрх мэдэл, сүр чадал хязгаарлагдан хумигдсан бололтой. Татар хааныг дэмжигч аймгууд түүнийг хаан ширээнд гарахаас өмнө ч байсан бөгөөд “...тэр (Датань) баруун газрын нүүдлийн нэгжийг захирч байсан. Тэрээр ард олны хайр хүндэтгэлийг хүлээж чадсан тул түүнийг түмэн олноороо дэмжиж Моуханьгэшэнгай буюу Вэй хэлээр “ялгуусан” хаан болгосон”⁸ тухай сурвалжийн мэдээ бий. Магадгүй баруун газрын гэгдэх Датанийг дэмжигч аймгууд Вэй, Цзинь улсын үед хэдэн зуугаар бүлэглэн нүүдэллэж байсан хүннүчүүдийн удам байх магадлалтай. Гэсэн хэдий боловч нүүдэлчдийн эл улс үндэслэсэн хаадынхаа аймгийн нэрээр алдаршсан учраас хятад сурвалжид жужан нэр тэмдэглэгдсээр байснаас харагдаж байна.

Харин улсаа байгуулсан жужанчуудын талаар судлаачдын харьцангуй санал нэгтэй, голлох үзэл баримтлалын талаар товчлон дурдъя. Шэньюаны (Ливэй ?-277 он)-ий хаанчлалын сүүлчээр нэгэн боол барин авч Мугулюй (мухар) гэж нэрлэсэн. Монгол (Мугулюй) эрийн цээнд хүрээд боолоос чөлөөлөгдөн морин цэрэг болжээ. Му-ди хааны үед дайчилгааны товоос хожимдон, цаазаар авахуулах болсон тул зугтаж уудам говийн хавцалд нуугдан, зугадагчдыг цуглуулан зуу гаруй хүн болоод Чуньтулинь аймгийг түшиглэжээ. Түүнийг үхсэнээс хойш хүү Чаругуй нь эрэлхэг дайчин байсан учир аймаг олонтай болж эхлээд, өөрсдийгөө нирун гэж нэрлэжээ. Вэй улсад алба барьж байв. Шицзу тэд мунхаг бөгөөд байдал нь тарианы өтгэй төстэй учир жуаньжуань гэж өөрчилсөн⁹ талаар хятад сурвалжийн мэдээг Г.Сүхбаатар дурджээ. Дотоод Азийн гүнд хүннүгийн дараа өрнөсөн угсаа соёлын үйл явц нарийн түвэгтэй замаар явагдсаныг судлаачдын янз бүрийн, нэгдмэл бус санал тодорхой харуулж байна. Өмнө дурдсан татар нэр жужаны үеэс угсаатны шинжийг олж эхэлсэн бол монгол нэр мөн адил энэ үеэс бий болсон талаар судлаачид дурджээ.

Монгол нэрийн талаар олон янзын санал дэвшүүлээд байгаа боловч дийлэнх нь ямар нэгэн сурвалжийн мэдээнээс гадуур, хийсвэр сэтгэлгээн дээр үндэслэгдсэн гал, гол, ус, уул гэх мэт бодит ертөнцийн махбодтой холбосон тайлбар болно. Ийм төрлийн таамаг хүлээн зөвшөөрөгдөх ямар ч боломжгүй, асуудлыг улам л хүндрүүлж, төөрөгдүүлэхээс өөр үр дүнгүй учир дурдах шаардлаггүй гэж үзвэй.

⁸ *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Введение, перевод и комментарии В.С. Таскина. М., 1984. стр. 271.

⁹ Сүхбаатар Г. *Монгол Нирун улс* (330-555). Улаанбаатар: 1992, 10-11.

Харин монгол нэрийг тэмдэглэсэн байж болох Вэй улсын болон Тан улсын сударт тэмдэглэгдсэн нэр, түүний утгын талаар хийсэн тайлбар илүү бодитой, үнэмшилтэй юм. Тухайлбал, Вэй улсын түүхэнд “...тонуул хийж явсан морьтонгууд (вэйгийн) хөмсөгнөөсөө ургасан үс толгой дээгүүр нь бүрхсэн боолыг барьжээ. Тэр өөрийн нэр, угсаагаа санахгүй байсан учраас түүний эзэн түүнд Мугулюй гэж хоч өгчээ. Мугулюй гэдэг нь “мүгэлэн толгойт”^{10*} гэсэн утгатай”¹¹ хэмээн дурджээ. Энэ нэрийг мухар гэсэн утгатай монгол үг болохыг К.Ширатори, Г.Учида, А.Коллауц, Х.Миякава, Ц.Хандсүрэн, Н.Ишжамц нарын эрдэмтэд хятад орчуулга, дуудлагыг баримтлан санал нэгтэй дэмждэг болохыг дурдаад “монгол” хэмээх үг болохыг Г.Сүхбаатар гүнзгийрүүлэн батлах оролдлого хийжээ¹². Б.Батсүрэн авиа, үг зүйн чиглэлийн тайлбарт хүч нэмсэн, түүхэн-утга зүйг илүү харгалзсан түүний тайлбар, үндэслэл бусдаас давуу болсон гэж дэмжжээ¹³.

Харин Н.Ишжамц Мугулюйнь “мухур-мухар” толгойт гэсэн утгатай бөгөөд XIII зууны Монголын сайд Мухулайн нэр мөн ийм агуулгатай гэж үзэн “Мугулюйн нэр нь монгол гэсэн нэр биш, харин мухар гэсэн тэмдэг үгээс үүссэн Мухулай гэсэн монгол нэр үг бололтой”¹⁴ хэмээн “монгол” нэртэй огт авцалдахгүйг учирлажээ. Энэ мэтээр мугулюй-монгол нэрийн холбоосын талаар эргэлздэг судлаачид цөөнгүй бий. Тэдний гол үзэл баримтлал нь 544 онд эмхтгэсэн Вэй улсын сударт нэр анхлан дурдагдсан “шивэй”, түүний дараа Суй улсын түүхэнд нань шивэй, бэй шивэй, бо шивэй, шэньмода шивэй, да шивэй гэж 5 салбарласан нэрээр гарч нэмэгдсээр 945 онд эмхтгэж дууссан Тан улсын хуучин сударт анхлан “мэнъу шивэй”, Тан улсын шинэ сударт “мэнва” гэж нэр дурдагдсан аймгийг “монгол” нэрийг анх дурдагдсан гэж үздэгт байгаа юм. Энэ үзлийг баримталдаг судлаачид дийлэнх олонх болно. Энэ тухай В.С.Таскин “мэнъу шивэй угсаатны нэр сонирхолтой, учир нь түүнийг хятад сурвалжид монголын тухай анхны үнэмшилтэй дурдсан гэж үзсэн бүх судлаачдын зөв”¹⁵ гэжээ. Энэ тайлбарыг

¹⁰ *мүгэлэн толгойт, мухлаган толгойт гэж үсээ хусуулсан хөвгүүдийг хочлон нэрлэх явдал 1970-аад оны сүүл хүртэл Хэрлэн хавь нутгаар лав байсан. Энэ нь манжийн үеийн мүглэн хэмээх гэгсгээх газрын нэртэй, түүнд хоригдогсод үсээ хусуулж, мулзгар болдогоос улбаатай байж ч болох юм. Эсвэл үсгүй хүнийг хэлэх монгол үг цээрлүүлэн хорих газрын нэр ч болсон байж болох билээ

¹¹ *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Введение, перевод и комментарии В.С. Таскина. М., 1984. стр. 267.

¹² Сүхбаатар Г. *Монгол Нирун улс* (330-555). Улаанбаатар: 1992, 176-179

¹³ Батсүрэн Б. *VI-X зууны монгол аймгууд (Түүх-угсаа гарвалын шинжилгээ)*. Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилох бүтээл. Улаанбаатар: 2012, 40.

¹⁴ Ишжамц Н. *Жужаны хаант улс* (IY-YI зуун). - *Монголын түүхийн зарим өгүүллийн эмхтгэл*. Улаанбаатар: 1998, 13

¹⁵ *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Введение, перевод и комментарии

дэмжигчид нь монголчуудын угсаа гарвалын түүхийг шивэйн аймагтай холбон тайлбарлагчид болно. Н.Я.Бичурин энд нэр гарсан мынву шивэйг монгол хэмээн үзэхдээ 806-820 оны хооронд Амар хавиас өнөөгийн монгол нутагт шилжин ирсэн гэж тайлбарласан бол Л.Р.Кызласов, Е.И.Кычанов нар X-XI зууны үед монгол нутагт байсан түрэг хэлтнүүдийн нөлөө сулран баруун зүгт шилжисхийхэд түүний нутагт анчин, загасчдын аж ахуйтан монголчууд эзлэн суух болсон гэх утгатай санаа дэвшүүлсэн байдаг¹⁶. Энэ маягаар монгол нэрийг тайлбарлагчид монголчуудын угсаа соёлын үйл явцыг шивэйн аймагтай холбогдуулан үздэг бол мугулюй-монгол гэж үзэгчид угсаатны үйл явцад шивэйн оролцоог үгүйсгэх хандлагатай. Зарим судлаачид аль алиныг үгүйсгэлгүйгээр монгол нэртэйгээр зүүн тийш нүүж Шивэйгийн нутагт очиж сууснаар “мэн-ү” шивэй (монгол) нэрээр хятадын сурвалжуудад тэмдэглэгдсэн¹⁷ гэж үзэж байна. Эл үзэл ихэд газар аван цэцэглэсэн нь “Цзю Тан шу”, “Син Тан шу” зэрэг сурвалжуудад “мэнъу шивэй”, “мэнва” гэж нэрлэгдсэн аймгийн талаар дурдагдсантай холбоотой бөгөөд судлаачид үүнийг “монгол” гэсэн угсаатны нэр эсвэл Эргүнэ-кунгийн аймгийн нэг нэр гэж бараг нягтлан үзэлгүйгээр шууд хэрэглэж байгаатай холбоотой¹⁸ билээ. Тухайлбал, Х.Пэрлээ Эргүнэ кунээс гарсан монгол аймгуудаас язгуурын монгол (мэнгу) нэрээ хадгалсан аймаг шивэйн олон аймгуудын дунд нутаглах болсон хэмээх санаа дэвшүүлээд, эдгээр шивэйчүүдийг монгол угсаат болохыг түүхэн газар зүйн судалгаагаар нотлох оролдлого хийхдээ адил тоотой байгааг харгалзан татар, шивэй аймгуудыг нэг гэж үзсэн байна. Г.Сүхбаатар сяньби, шивэй хоёрыг нэг үг хэмээн үздэг судлаачдын саналыг үгүйсгээгүй бөгөөд татар, шивэйг нэгэн нэр болно гэх үзлийг баримталжээ. Д.Баяр бичихдээ гучин татарыг мөн л шивэйн аймгуудыг нэрэлсэн хэлбэр гээд тэдний дотроос мэнъу шивэй, хожмын олхонуд болон өмнөх сяньби угсааны ухуань нэрээрээ шивэй аймгуудын дунд хадгалагдаж ирсэн хийгээд сяньби нэр сунжран шивэй болсон гэх үзлийг баримтлан тэдний үндсэн хэсгийг монголтой адил дунху, сяньби гарвалтай аймгууд бүрдүүлж байна

В.С. Таскина. М., 1984. стр. 364

¹⁶ Бичурин Н.Я. *Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена*. Т.1.М.-Л., 1950. с. 377, Кызласов Л.Р. Ранние монголы (к проблеме истоков средневековой культуры) Сибирь, Центральная и Восточная Азия в средние века. Новосибирск., 1975.с. 173, Кычанов Е.И. *Монголы в VI первой половине XII в Дальний Восток и соседние территории в средние века*. ИКВА Новосибирск, 1975.с.173

¹⁷ Пэрлээ Х. Гурван мөрний монголчуудын аман түүхийн мөрийг мөшгөсөн нь. // *Түүхийн судлал*. Т. VIII. Fasc 6. 1969, Дэлгэржаргал П. *Монголчуудын угсаа гарвал*. Улаанбаатар: 2005, 127

¹⁸ Билэгт Л. *Раннемонгольские племена* (этногенетически изыскания на основеустной истории). Улаанбаатар: 2007 с.197

гэж үзсэн байна¹⁹. П.Дэлгэржаргал Шивэйгийн аймгууд болон гучин татар нь нэг зүйл гэдэг нь түрэгийн руни бичээс, хятад сурвалжийн мэдээнүүдээр батлагдахгүй болохыг онцлон тэмдэглээд “Тан улсын судар”-т тэмдэглэгдсэн Мэн-ү шивэй нь манж түнгүс угсааны Шивэй аймаг бус, харин түрэгүүдэд цохигдон зүүн тийш шахагдаж, Шивэй аймгуудын дунд шилжин суусан Монгол аймаг²⁰ гэх мэтээр тайлбарлажээ.

Жужаны дотоодод гарсан зөрчил тэмцлийн хамгийн хурц, ширүүн үйл явц нь өмнө дурдсан угсаа залгамжлал шилжсэн үйл явдал бололтой бөгөөд 414 онд өрнөсөн хаан ширээний төлөөх Дисуюаний хүү Вэньгэти, түүний дүү Пухуний удмын хооронд “...олон мянган цэрэг гарган хоорондоо байлдаж, ахархан хугацааны бага шиг иргэний дайн болж, хааны угсааны язгууртнаас Булучжэнь, Шэба нар алагдсан”²¹ үйл явдал болжээ. Үүнтэй төстэй үйл явдал Абуль Гази хааны “Түрэгийн угийн бичиг”-т “Иль хан монголчуудын эзэн байсан. Бид урьд нь Татарын ес дэх үеийн хаан нь Сююнуч хан байсан гэж хэлсэн. Иль хан ба Сююнуч хан нэг үеийнхэн байжээ. Тэдний дунд байнгын дайн тулаан, дээрэм тонуул гарна.татарчууд монголчуудыг хараад эргэж байр хийн тулалдаж ялаад монголчуудыг нэгмөсөн сөнөөв” гэж дурдагджээ²². Тиймээс Судрын чуулган дахь монгол аймгийг зугтахад хүргэсэн ялагч аймгийг түрэг аймаг гэж тэмдэглэснээс үүдэн эртний түрэгүүд шахсан гэх үзэл бат бөх тогтсон болохыг Б.Батсүрэн шүүмжилжээ. Тэрээр түүхэнд түрэг нэр гарахаас 150-иад жилийн өмнө энэ үйл явдал болсон бөгөөд “монголчуудыг устгаж, үлдсэн нь Эргүнэ кунд шургахад хүргэсэн этгээд бол Татар улс буюу татар овог, аймгууд”²³ гэсэн нь уг үйл явцын эхлэл байх боломжтой.

Эргүнэ кунд одогсод

Жужаны хаадын угсаа залгамжлал нэгээс нөгөөд шилжсэн нь хэрэг дээрээ дунху болон хүннү угтай эртний монгол аймгуудын дотоодод өрнөсөн томоохон зөрчлийн үр дагавар байх магадлалтай талаар бид дурдлаа. Эрх мэдлээ алдсан мугулюй (монгол) угсааныхан Датань хаантай хийсэн Булучжэнь нарын тэмцэл,

¹⁹ Монгол улсын түүх. Тэргүүн боть Улаанбаатар: Адмон, 2003, 353-355

²⁰ Дэлгэржаргал П. Мэнгу шивэй аймгийн угсаа гарвалыг нэхэн сурвалжлах нь. МУИС-ийн ЭШБ. Түүх-1. № 188 (14). 2002, 10

²¹ Сүхбаатар Г. Монгол нирун улс (330-555). Улаанбаатар: 1992, 101

²² Батсүрэн Б. VI-X зууны монгол аймгууд (Түүх-угсаа гарвалын шинжилгээ). Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилох бүтээл. Улаанбаатар: 2012, 16

²³ Батсүрэн Б. VI-X зууны монгол аймгууд (Түүх-угсаа гарвалын шинжилгээ). Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилох бүтээл. Улаанбаатар: 2012, 20

Абул-Газийн тэмдэглэлд дурдагдсан монгол, татарын тулааны мэдээ хооронд адилтгах зүйл олон байгаа талаарх дүгнэлтийг өмнө дурдсан. Энэ мэтээр монгол угсааныхан улс төр, эдийн засгийн нөлөөгөө Жужаны нийгэмд богино хугацаанд алдаж, өөрсдийн байр суурийг хадгалах шинэ орон зай шаардлагатай болсны улмаас Татарын мэдлийн хүрээнээс зайлан одсон байна. Чухам тэдний очсон газар нь Рашид Ад-Дин монголчуудын аман мэдээгээр Киян, Нукуз нар толгойлон одсон Эргүнэ-кун хэмээн тэмдэглэсэн нутаг бололтой. Эргүнэ-кунд очсон хийгээд хэрхэн тэмцэн гарсан талаар судлаачид олон удаа дурдсан. Л.Билэгт, Б.Батсүрэн, Б.Р.Зориктуев болон бусад судлаачид өөрсдийн бүтээлдээ хүрч очсон, хийгээд гарч ирсэн, хугацаа, байрлал зэргийг дэлгэрэнгүй үндэслэлтэй дурдсан учраас давтан нурших нь зохимжгүй болно.

Л.Билэгт Эргүнэ-кунг орчин үеийн Оросын нутаг дахь Аргуны нуруу орчмын нутаг болохыг тогтоож, сурвалжид тэмдэглэснээр умардын анчин-загасчид болох Шивэйчүүдийг Бурхан халдун уулнаа ирсэн хэмээх үзэл баримтлагчдыг шүүмжилжээ. Тэрээр шивэйчүүдийн газар нутгийн талаар тэмдэглэсэн нангиадын гурван сурвалжийн мэдээг харьцуулан судлаж, тэдний уугал нутгийг Амар мөрний умард эргийн сав, Якут болон Агнуурын тэнгис орчмын цасан шуурга ихтэй нутаг²⁴ хэмээн үзээд, Эргүнэ-кун буюу одоогийн Чита мужийн нутаг дахь Аргун нуруу шивэйн нутгийн гадна үлдэж байгаа нь тэднийг монголчуудтай угсаа гарвалын холбоогүй болохын нэгэн нотолгоо гэжээ. Мөн анчин, загасчид болох шивэйчүүд нь монголчуудын өвөг болохыг дундад зууны Монгол, Алтан Ордын улсад дэлгэрсэн халаах ханз бүхий “... Амар хавь, Манжуур, Приморийн мохэ, кидан, зүрчид зэрэг манж-түнгүс ба монгол хэлт ойн ард түмнүүдийн дунд өргөн тархсан”²⁵ сууцаар батлахыг оролддог зарим судлаачдын үзлийг няцааж, Евразийн нутгаар өргөн дэлгэрсэн уг байгууламж нь үүнийг хэрэглэгч аль нэг угсаатны хөгжлийн түүхтэй холбон үзэх бололцоогүй гэж үзсэн байна. Л.Билэгтийн тогтоосон Эргүнэ-куны байрлал нь аргачлалын хувьд илүү шинжлэх ухааны үндэслэлтэй болсон бөгөөд хожмын Хасарын ургийн мэдлийн нутаг байж, түүхэн үйл явдал өрнөж байсан газар тул зарим судлаачид түүнийг “асуудлыг нэг мөр” болгож шийдсэн гэж үнэлжээ. МНТ-ны § 141 “...Жажирадай Жамухыг хан өргөө хэмээн азарга гүү хөндөлдөн цавчилдан андгайлалцаж тэндээс Эргүнэ мөрөн уруу нүүсэн” мэдээ байгаа нь монгол язгууртны зөрчлийн улмаас тэр зүгт нүүн хулжин

²⁴ Билэгт Л. Шивэйцы и Монголи. - Б.Билэгт. *Раннемонгольские племена* (этногенетические изыскания на основеустной истории). Улаанбаатар: 2007 с. 198

²⁵ Кызласов Л.Р. Ранние Монголы. - В кн. “*Сибирь, Центральная и ВосточнаяАзия в средниевека*” Т.III.Новосибирск, 1975, с. 171, 173

оддог өвөг дээдсийн уламжлал давтагдаж байна гэж бас үзэж болох билээ.

Судлаачдын үзэж буй Эргүнэ-кун хийгээд мэнгү шивэй нарын нутаг хэмээн зааж байгаа газар оронд Оросын судлаачдын шивэй (түрэг бичээсэнд отуз-татар) нартай холбогдуулан үздэг “бурхотуй” –н соёлыг үлдээгчдийн дурсгал тархсан нь монгол аймгууд уг археологийн соёлыг бүрэлдэхэд оролцсон байх боломжтойг харуулж байгаа юм. Өвөрбайгалын Зүүн Өмнөд нутгийн “бурхотуй” соёлын дурсгалын шинж нь бусад оршуулгаас зүг чигийн хувьд өргөрөг чиглэлд (толгойг баруун-баруун хойш) хандуулдгаараа ялгардаг ба аажимдаа малын яс заавал дагуулах уламжлал халагдан харин хавтгай ёроолтой, шавран гүвгэр ба сараачмал хээтэй ваар, хүннү хэлбэрийн нумны урт ясан наалт бүх төрлийн ясан зэвүүд зэрэг өөрийн гэсэн тогтсон оршуулгын эд өлгийн зүйлтэй болжээ²⁶. Чухам ийм нийтлэг шинж тэмдгээр Зүүн Өвөрбайгалын тал хээр, ойт хээр, ой тайгын бүс, өндөр уул, гол мөрний өргөн хөндийн зэрэг газар зүйн харилцан өөр орчин бүхий дурсгалуудыг нэгэн “соёл”-ын хүрээнд хамруулсан байна. Ийм шинж бүхий олдворууд илэрсэн бэрх бэхлэлт хамгаалалт бүхий сууц, тэдний оршин суугчдын нүсэр оршуулгын газрууд, тал нутгийн малчдын үлдээсэн булш зэрэг олон янзын дурсгалууд “бурхотуй”-н соёлын хүрээнд багтаж байна. Бурхотуйн онцлог гэгдэх эд өлгийн чуулбар дотор хүннү хэлбэрийн нумын наалтыг чухал тодруулагч гэж тооцсон бол бүр эрт Ганьсугаас зүүн хойдийн хязгаар хүртэл МЭӨ Y-III зууны үеэр өргөн тархсан байсны дотор тохиолдлын ганц нэг жишээг тооцвол бүр МЭӨ YI зууны дурсгалуудад магадгүй түүнээс ч эрт байж мэдэхээр байна²⁷. Тухайлбал, Юйхуанмяотой бараг зэрэгцээ цаг үеийн Бэйсиньбаогийн дурсгалт газраас илэрсэн бөгөөд МЭӨ YI-Y зууны заагаас хожуугүй болно. Монгол, Өвөрбайгалын нутгаар тархсан дөрвөлжин булшны соёлын дурсгалаас цуурхай сурвалжтай ясан зэв 4 булшнаас 7 ш олдоод байна²⁸. Умард Хятад нутгаар Цингийн өмнөх дурсгалуудад ийм зэв бараг таардаггүй бол Алтай, Тувад цуурхай сурвалжтай яс (эврэн) болон хүрэл зэв МЭӨ YII-YI зууны дурсгалуудад мэдэгджээ. Хүннү нумын хэлбэр дараагийн нүүдэлчдэд уламжлагдсан талаар археологчид батлан үгүүлдэг. Иймээс нумын наалт, ясан зэв нь зүүн Өвөрбайгалын нутгаар эрт үеэс эхлэн тархсан түгээмэл зүйл болно. Шавар савны хувьд амсрын доогуур ташуу

²⁶ Асеев В.И., Кириллов И.И., Ковычев Е.В. *Кочевники Забайкалья в эпоху средневековья (по материалам погребений)*. Новосибирск, 1984. с. 97

²⁷ Ковалев А.А. *Происхождение хунну согласно данным истории и археологии*. Европа-Азия: Проблемы этнокультурных контактов. С-Пб., 2002. с. 150-193

²⁸ Цыбиктаров А.Д. *Культура плиточных могил Монголии и Забайкалья*. У-Удэ., 1998. с. 62. Рис 67. 5,6

товгор хэрчлээстэй бурхотуй хэлбэрийн ваар Өвөрмонголын сяньби булшнаас (Ла бү да шийн 92M5, Мөнгөн чулууны М3) болон Зорголын соёлын дурсгалаас ижил ваар илэрчээ²⁹. Хүннүд уламжлагдсан шавар саван дээрх бяцхан товойлгосон нугачаа, эрчлээсэн хээ нь Амар хавийн ба Приморийн керамикийн үндсэн шинж³⁰ болох учраас эд өлгийн хувьд бурхотуйн соёлыг ялгах үндэслэл эргэлзээтэй санагдана. Аж ахуйн олон хэв шинжийг илэрхийлж буй учраас судлаачид дотор нь 4 хэлбэр болгон үзжээ. Үүнээс Ононгийн хэлбэрийн дурсгалууд нь баруун гурван зүгт хандуулан тэнэгэр байдалтай тавих зан үйл давамгай. Бараг бүх оршуулганд шавар, хусан сав дагуулсан ба зэр зэвсгээс ясан зэв, ахуй, гоёлын эдлэлд хүрэл (нэг тохиолдолд алт-Онохтыч №11) ээмэг, зэс, төмрөн бугуйвч, зузаан төмөр тэвнэ, өвөрмөц хэлбэртэй товруу, зүүлт зэргийг IV-VIII зуунаар холбогдуулан үзэж байна. Энэ үед булшнаас шавар сав аажмаар түрэгдэж, өмнөх үеийн булшнуудад давамгай байсан ясан зэв төмрөөр солигдох болсон зэрэг нь монголын өмнөх үеийн оршуулгын чухал баримтжуулалт болно³¹.

Бурхотуйн суурингуудын талаар их төлөв Шилка голын хөндийгөөр байгалийн саад ихтэй, эгц эрэг, цавчим тохойд сонгож байрласан байдалтай бөгөөд түүний дотор харилцан адилгүй тоотой, заримдаа 70 хүртэл хагас нүхэн гэр сууцтай бөгөөд суурин амьдралыг гэрчлэх эд өлгийн зүйлс олддог бөгөөд адуу, гахайн яс, төмрийн үлдэц, ваар савны хагархай зэрэг зүйлс илэрдэг талаар судлаачид дурджээ³². Дээрх судлаачдын бүтээлээс үзэхэд бурхотуйн суурин төвдөө галын оромтой бөгөөд харин зөрчид, кидан адил халуун ханз буюу кан байхгүй онцлогтой байна. Приморийн орчимд кан маш эртнээс уламжлалтай бол Амарын дунд урсгал хавьд бохайчууд энд орж ирсэн зөрчидийн үеэс л үзэгдэж эхэлсэн³³ учраас бурхотуйн суурингуудад кан нэвтрээгүй бололтой. Ийнхүү бурхотуйн соёл нь дундад үеийн Зүүн Өвөрбайгалын нутагт болсон угсаатны шилжилт хөдөлгөөн, үйл явцын шууд тусгал учраас хэт өргөн хүрээг хамарч байгаа нь ихээхэн

²⁹ Юэ Гоу-Мин. *Өвөрмонголын нутаг дахь Сяньбигийн археологийн дурсгалуудын судалгаа* (Түүхийн ухаанаар магистрын зэрэг горилсон бүтээл) Улаанбаатар: 2011, Яремчук О.А. Особенности погребального обряда населения Восточного Забайкалья в хунно-сяньбийскую эпоху. Забайкалье в геополитике России. У-Удэ, 2003

³⁰ Бородянский Д.Л. *Кроуновско-хунские параллели*. - Древнее Забайкалье и его культурные связи. Новосибирск, 1985

³¹ Асеев В.И., Кириллов И.И., Ковычев Е.В. *Кочевники Забайкалья в эпоху средневековья (по материалам погребений)*. Новосибирск, 1984. с. 109-110

³² Асеев В.И., Кириллов И.И., Ковычев Е.В. *Кочевники Забайкалья в эпоху средневековья (по материалам погребений)*. Новосибирск, 1984. с. 18, Дашибалов Б.Б. *На монголо-тюркском пограничье* (Этнокультурные процессы в Юго-Восточной Сибири в средние века). Улан-Удэ, 2005.с.54-55

³³ Деревянко Е.И. *Древние жилища Приамурья*. Новосибирск, 1991. с. 144

эргэлзээтэй. Тухайлбал, Чита хотын Өвөрбайгалын Багшийн дээд сургуулийн Дээд Амарын хээрийн судалгаагаар Зорголын соёлыг ялгасан байна. Энэ нь хүннүтэй илүү төслөг учраас түүний эздийг монгол сяньбитай илүү холбоотой гэж үзжээ³⁴. Ийнхүү бурхотуйн соёлын судалгаа гүнзгийрэхийн хирээр зөрчилтэй асуудлууд улам нэмэгдсээр байна. Тэдний эздийг А.П.Окладников Бурхотуйн соёлын хэрэглэгдэхүүн, ялангуяа Алс Дорнодын Амар хавь, Приморийн ваартай төслөг байдлаар нь “нэгдүгээр мянганы эхээр Онон голын оршин суугчид Амарын хязгаарын аймгуудтай соёл-угсааны харилцаатай магадгүй төрөл байж болохыг үгүйсгэхгүй” гэжээ. Голын татар, су монгал буюу Чингисхааны талын монголоос ялгаатай, анчин загасчид гэжээ³⁵. И.И.Кириллов Онон, Хэрлэн, Аргунь голын хөндийд нутаглаж байгаад умард зүг одсон дунху нарын үлдээсэн дурсгал байж болно гэж бурхотуйг үзжээ. Яваандаа шивэйн дунд шинээр монгол хэлтнүүд бий болох сурвалж болсон гэжээ. Хожмын бурхотуйн дурсгалууд шивэйтэй холбогдож болно³⁶ гэсэн бол Е.В.Ковычев бурхотуйн соёлыг шивэйн монгол хэлт аймгуудтай холбон, түүнийг хөрш эртний түрэгүүд “отуз татар” хэмээн нэрлэдэг³⁷ гэх мэтээр бурхотучуудын угсаатны хамаарлыг зааж байна.

Монголчууд эх нутагтаа эргэн ирсэн нь

Судрын чуулган дахь “Эргүнэ кун”-ы аман түүх хийгээд Монголын нууц товчооны эхлэлийг холбон үзэх нь монголчуудын угсаа гарвалын түүхэн үйл явцын амьд холбоос болж байгаа учраас чухам үүнд үндэслэгдсэн түүхийн судалгааны цогц үзэл баримтлал, дэг сургууль бий болжээ. Энэ нь бүр эрт цагаас эхлэлээ тавьсан бөгөөд одоо бидэнд лавтай мэдэгдэж буйгаар 400 гаран жилийн тэртээгээс монголчууд өвөг дээдсээ чухам хаанаас ирж, хаагуур нутаглах болсон талаар түүх, бичигтээ тэмдэглэсээр иржээ.

МНТ-ны эхлэл “Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий инү Хоо марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ, Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батачихан ажгуу”³⁸ хэмээх мэдээг хожмын монгол сурвалжуудад буддын түүх бичлэгийн зарчмыг баримтлан Бөртэ чинойг Энэтхэг, Төвд хаадаас удамлуулан “баяжуулж” бичсэн байна. Тухайлбал, Бөртэ чоно “Шар тууж”,

³⁴ Яремчук О.А. Особенности погребального обряда населения Восточного Забайкалья в хунно-сяньбийскую эпоху. - *Забайкалье в геополитике России*. У-Удэ, 2003

³⁵ Окладников А.П. Бурхотуйская культура железного века в юго-западном Забайкалье. - *Тр.Бурят. коп. НИИ*. Вып.3 У-Удэ, 1960

³⁶ Кириллов И.И. *Восточное Забайкалье в древности и средневековье*. Иркутск, 1979.с.59-65

³⁷ Ковычев Е.В. *История Забайкалья* (1-сер. II тыс н.э.). Иркутск, 1984

³⁸ МНТ. Эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. Улаанбаатар: 2006

“Эрдэнийн товч”-д өгүүлснээр Гонбо оронд Гоо марал хэмээх бүсгүйтэй гэрлээд, тэнгис далайг гаталж дорно зүгт явж Бэд улстай уулзахад тэд түүнийг ноёноо болгодог. Харин нэр нь тодорхойгүй “Алтан товч”, Лу “Алтан товч”-д Бөртэ чоно Жад(Иэд) хэмээх оронд Гоо марал хэмээх бүсгүйтэй гэрлэдэг гэх мэтээр өгүүлэхдээ түүний очсон орныг Жадын (Зад, Йэд) газар, Бидэ (Бэд) улс зэргээр тэмдэглэсэн байна. Ийнхүү монгол сурвалжуудад нэр гарсан “bede” (бидэ улс)–хэмээх орон байр заасан нэр үг дараа нь нэр дурдагдаж буй учир эхлээд “Jad-un yajar” (Жад, Йэдийн газар)-ын талаар товч дурдах нь зүйтэй хэрэг болно.

Монгол сурвалжуудад Бөртэ чинойн ирсэн газрыг тэмдэглэсэн нь

Д/д	Сурвалжийн нэр	Очсон газрын нэр	Ишилсэн зохиол
	Дарма гүүш. Алтан хүрдэн мянган хигээст	yad-un yajar	Дарма гүүш ..., 2006:33
	“Хаадын үндэсний хураангуй Алтан товч нэрт судар”	Jadyajar	Хаадын..., 2006:35
	Лу. Алтантовч	Jad-un yajar	Лувсанданзан 2006:32
	Монгол боржигид овгийн түүх	Jad-un yajar	Ломи 2006:18
	Сүмбэ хамбын Багсамжонсан	Peta ulus	Ишбалдан. “Эрдэнийн Эрих” зохиолын кирилл үсэгт буулгаж, тайлбарласан Бүрнээ. УБ., 2006. т. 65-66 дам ишлэв
	Шар тууж	“bede”	Мөн тэндээс
	Мэргэн гэгээний Алтан товч	“bede”	Мөн тэндээс
	Эрдэнийн товч	“bede”	Мөн тэндээс
	Гангын урсгал	“bede”	Мөн тэндээс
	Рашпунцаг. Болор-Эрих.	yad-undalang	Рашпунцаг ..., 2006:18

Энд дурдагдаж буй “jad, jat, yad” хэмээх үгийг МНТ-нд Жамухын овгийн үүслийг дурдсан бүлэгт “... jatirgen-ü kö’ünbüle’eke’enjajiradai nereyitbe jadaran-u ebügeterebolba”³⁹ гэж дурдсан “jat” хэмээх үгтэй ижил утгаар ойлгож эртний түрэг хэлний “гадны, харийн”⁴⁰ гэж утгачлан үзэх нь судлаачдын дунд түгээмэл байна. БНХАУ-д хэвлэгдсэн зарим толь бичигт “ǰati, ǰad – (хуучны) харь, бусад, гаднын (“Жат иргэн” МНТ&40, “Бөртэ чинуа умар зүг тэнгис далайг гэтлэн жад газар ирээд” Хураангуй А.то)”⁴¹ гэж тайлбарласнаас тодорхой харагдана. МНТ-

³⁹ Louis Ligeti, *Historie secrete des mongols*, Monumenta Linguae MongolicaeCollecta-I, Akadémiai Kiadó, Budapest, 1971. § 40, p.30.

⁴⁰ *Древнетюркский словарь* (Редакторы: В.М.Наделяев, Д.М.Насилов, Э.Р.Тенишев, А.М.Щербак). Л., 1969. с. 247.

⁴¹ *Монгол үгсийн язгуурын толь*. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1987. Тал 2345

ны § 40 –д “jat” иргэн хэмээх утгаар дурдагдсан бол §143-т “... зад мэдэх ажээ. Задлах болсонд зад урваж нөгөөх нь (өөрсөн) дээр (нь) зад болжээ”⁴² гэж “ид шидээр салхи, бороо оруулах” хэмээх утгыг илэрхийлжээ. МНТ-нд дурдагдсан “Ж(з)ад”-ыг илтгэсэн дээрх утгууд нь бидний хөндөн буй “Jad-un ʎajaɣ”-тай хэрхэн холбогдож болох талаар зарим судлаачид сонирхолтой санал дэвшүүлжээ. Лу. Алтантовч тэргүүт XVII зууны монгол сурвалжуудад нэр дурдагдан буй “Задын газар”-ыг Бурхан халдун уул(Онон голын эх) оршдог Хэрлэн, Онон, Туул гурван голын хавьд бий гэж П.Б.Коновалов үзсэн⁴³ бол С.Ш.Чагдуров өнөөгийн Өвөрбайгалын нутаг Джид голын орчин гэж тайлбарлан түүнд цутгах Улекчин голын нэрийг Чингис хаанаас өмнөх 6-р үеийн өвөг болох Хайдугийн ач Өлөгчин чинэ гэх домгийн бус бодит хүний нэртэй холбохгүй байхын аргагүй хэмээн шууд хамаатуулан бичжээ⁴⁴. Их төлөв буриадын голдуу эрдэмтэд энэ мэтээр Эргүнэ хун болон Жадын газар, Бидэ улсын газрыг Байгалын орчинд зааж байна.

Г.Мэнэс МНТ-нд дурдагдсан Жадараны өвөг болсон “Жат” иргэнийг “Судрын чуулган”-нд дурдагдсан Жалайр аймгийн 10 салбарын нэг “Джат” хэмээх ураг салбарын нэртэй холбон хожмын монгол сурвалж бичгүүдэд дурдсан “Jad-un ʎajaɣ”-нь Бөртэ Чинойн үед бодитой оршин байсан “Жад” хэмээх иргэн улсын нэр гэж үзжээ⁴⁵. Харин “задын газар” буюу зад хийдэг газар гэж тайлбарлах саналыг Г.Сүхбаатар, Ю.Болдбаатар нар дэвшүүлжээ⁴⁶.

Мөн “Jad” хэмээх үг нь эртний түрэг хэлэнд “дурсан санах, дурсамж”⁴⁷ гэсэн утга зааж байгаа учраас “санан дурсах, дурсамжийн газар” гэсэн агуулгатай гэж үзэж бас болно. Хэдийгээр МНТ-нд “газар”- хэмээх үг олон удаа давтагдаж байгаа ч “jad”-ын газар хэмээх нэр байхгүй. Харин дурдсан үгийг “дурсан санах, дурсамж” хэмээх утгаар ойлговол МНТ-ны § 70-д “Тэр хавар Амбагай хааны хатад Орбай, Сохатай хоёр ихэсийн газар тайлга гаргасанд Өэлүн үжин хожимдож ...”⁴⁸ гэсэн мэдээтэй дүйлгэн үзэж болно. Энэ зүйлд дурдагдсан “yukes-e qajaru”

⁴² МНТ. Сонгомол эх. УБ., 2005

⁴³ Коновалов П.Б. *Этнические аспекты истории Центральной Азии* (Древность и средневековье). У-Уде., 1999. с.109.

⁴⁴ Чагдуров С.Ш. Горная Бурятия-прародина всех монголов. *Филологический сборник*. У-Уде, 1998

⁴⁵ Мэнэс Г. “Монголын нууц товчоон” дахь эхний хоёр мөрийн оньсого буюу “Чингис хааны язгуур” хэмээх гарчиг нэрийг нягтлах нь // *SE*. Tom. XV, Fasc 8. 2003.

⁴⁶ Сүхбаатар Г. *Монгол Нирун улс* (330-555 он). Улаанбаатар: 1992, 162; Болдбаатар Ю. *Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн задын шүтлэг*. Улаанбаатар: 2008, 25-26.

⁴⁷ Древнетюркский словарь (Редакторы: В.М.Наделяев, Д.М.Насилов, Э.Р.Тенишев, А.М.Щербак). Л., 1969. с. 222.

⁴⁸ Цэрэнсодном Д. *Монголын нууц товчоо*. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Улаанбаатар: 2000

(Ихэсийн газар)-нь дам утгаараа хожмын монгол сурвалжуудад үгүүлсэн “Jad-un qajar”(Жадын газар)-тай холбогдож болохоор байна. Гэтэл МНТ-нд нэр гарах мөнхүү “Ихэсийн газар”-ыг өвөг дээдсийн шарилыг онголсон газар орон гэж судлаачид ташаа ойлгосоор ирсэн нь харамсалтай. Бид энэ талаар зарим нэг залруулга хийхийг оролдов.

МНТ-ны 也客薛合礼鲁亦捏鲁合鲁黑三突兒 (ye-ke-xue he-zha-lu yi-nie-lu he-lu-hei-san tu-er) хэмээх мөр бүхий 70-р зүйлийг “Тэр хавар Амбагай хааны хатад Орбай, Сохатай хоёр ихэсийн газар тайлга гаргасанд Өэлүн үжин хожимдож хүрч очоод, хожимдуулсан Орбай, Сохатай хоёрт Өэлүн үжин өгүүлрүүн: “Есүхэй баатрыг үхэв үү гэж хөвгүүдийг минь том болоогүй гэж ихэсийн хишгээс /идээ/ шүүснээс, сархадаас яахан хождуулав та нарүзтэл /амьхандаа/ идэх Үл сэрээн нүүх болов та нар” хэмээжүхэй⁴⁹ гэсэн утгаар судлаачидсийрүүлдэг байна. Харин “yekes-e qajaru ineru” хэмээх үгсийг хэрхэн тайлсанаас үүдэн судлаачдын санал хуваагдахад хүрчээ. Тухайлбал, “ineru” хэмээх үгийн талаар судлаач Элдэнтэй, Ардаажав нарын чинару (чанар) гэж бөөгийн тахилгын ёстой холбон тайлбарласныг (1986:135) хамгийн боломжтой хувилбар хэмээн Д.Цэрэнсодном дэмжиж “... ихэсийн газар тайлга гаргасанд” хэмээн хөрвүүлжээ. Үүнтэй ижил утгатай тайлбар МНТ судлаачдын дунд нэлээдгүй бий. Ш.Чоймаа МНТ-ны 70-р зүйлийг “Тэр хавар ... ихсээ газраа тавиг тайлга гаргасанд ...”⁵⁰ хэмээн сийрүүлсэн байхад Мансан мөн зүйлийг “Тэр хавар ... дээдсийн тахилгын газар тайлгын идээ өргөхөд” хэмээн буулгаад, “Ихэсийн газар инару гарсанд” хэмээх эдгээр үгсийг Дээдсийн тайлгын газар өвөг дээдэсдээ тайлга идээ өгөх ёслолыг зааж буй⁵¹ хэмээн тайлбарлажээ. Эдгээр бүгд “Ихэсийн газарт очин тахилга үйлдсэн” хэмээх ерөнхий утгатай болох нь илт боловч чухам “ихэсийн газар”-ын талаар тодорхой тайлбар хэлээгүй байна. Ш.Гаадамба 70-р зүйлийг “ Тэр хавар ... ихсийн газар янар гарсанд...” хэмээн сийрүүлэн, “...ихсийн газар (өвгөдийн оршуулгын газар) янар (тогтсон хугацаанаас наана) Өэлүн үжинд хэлэлгүй гарсан”⁵² хэмээн тайлбарлажээ. Түүний эл тайлбар өмнөх судлаачдынхаас ихээхэн өвөрмөц болох нь “ineru” гэх үг ямар нэг тахилга, зан үйлийн холбогдолтой бус эртний монгол хэлний цаг заасан “янар” хэмээх үг гэж үзсэнд оршино. Саган сэцэний Эрдэнийн товчид:

⁴⁹ Цэрэнсодном Д. *Монголын нууц товчоо*. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Улаанбаатар: 2000

⁵⁰ МНТ: Эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. Улаанбаатар: 2006

⁵¹ Мансан. *Шинээр орчуулж, тайлбарласан МНТ*. ӨМ-ын Ардын Хэвлэлийн хороо, 1985

⁵² Гаадамба Ш. *Монголын нууц товчоо*. Худам (язгуур эртний) Монгол бичгээр Монгол бичиг, утга судлалын үүднээс Ш.Гаадамбын төсөөлөн нягталж сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. Улаанбаатар: 1990. 213-р тайлбар, 260

Түүгээр үнэн бодь хутгийг олохоо янар

Тэрхүү буянт оройн багшийг шүтэгдэх

Төгөлдөр аху ёсыг ухахаа янар

Тийн алгасал үгүй еэ олныг сондох⁵³ гэж дурдагдсан жишээнээс үзэхэд манай дундад үеийн бичгийн хэлнээ уг үг хэрэглэгдсээр байсныг харж болох билээ.

МНТ-дахь Ихэсийн газрын талаар үгүүлсэн байж болох 70-р зүйлийн эл үгүүлбэрийг зарим судлаачид арай өөр утгаар тайлбарлаж байна. Жишээлбэл, Рахевильз “Тэр хавар ... өвөг дээдэстээ *qajagu inegu* тахилга үйлдэхэд ...” гэсэн утгаар сийрүүлэн, уг ёслолд бэлтгэсэн идээ ундаа нь өвөг дээдсийн таалалд хүрч, улмаар үр хойчис бидний элбэг хангалуун байдал урт удаан үргэлжлэж байхыг хүссэн утга бүхий тусгай шившлэгэт үгс хэмээн дээрх хоёр үгийг тайлбарлажээ. Тэрээр “Ихэсийн газар” хэмээх тусгайлсан газар ерөөс байгаагүй хэмээх саналаа эдүгээ Монголын эзэнт гүрний үеийн хаад, язгууртны оршуулгын газар олдоогүй байгаа явдлыг үүний нэгэн нотолгоо хэмээн үзжээ⁵⁴. Түүний эл тайлбараас үзэхэд “Ихэсийн газар”-нь мөн л хаад язгууртны оршуулгын газар хэмээх ойлголттой байгаа нь тодорхой мэдрэгдэж байна.

“Судрын чуулган”-д “Ихэсийн газар”-ийн нэр огт дурдагдаагүй ч ойн урианхай аймгийн тухай тэмдэглэлд “Одоогийн эл улсад (Иранд) энэ аймгаас сураг нь дуулдмаар хэн ч байхгүй. Гэвч Чингис хааны үед энэ аймгуудаас зүүн жигүүрийн эмирүүдийн нэг Удач гэгдсэн эрхэм байсан. Түүний мянгат Бурхан Халдунд оршдог Чингис хааны их гурукийг хамгаалахаар томилогдсон”⁵⁵ хэмээх мэдээ нь судлаачдын тайлбарлаж буй их хаад, дээдсийн оршуулгын газрын талаарх төсөөлөлтэй дөхөж очих юм. Судлаачид “гурук” хэмээх үгийг монгол хэлний “(*xorig*)” хориг, хоригул гэсэн үгтэй холбон тайлбарлаж байна. Тулуй, Хубилай, Мөнх хаадын болон гэр бүлийн бүх оршуулгууд энэхүү их гурукд байдаг талаар “Судрын чуулган”-нд тэмдэглэгдсэн нь Их Гурук буюу Их Хоригийг Монголын их хаадын оршуулгын газар хэмээх ойлголт түгэхэд хүргэжээ. Манай ахмад үеийн судлаачид Хэнтий хан уулын ойролцоо Хориг, Хориуд хэмээх нэртэй газрууд байгааг тогтоож, мөнөөх “Их хориг”-нь ийнхүү газрын нэр болж үлдсэн талаар санал дэвшүүлсэн билээ⁵⁶.

Сүүлийн жилүүдэд Бурхан Халдун уулын Тэнгэрийн овоог археологийн хэв

⁵³ *Эрдэнийн товч*: Монголын түүхэн цуврал бичиг. 8-р боть. Улаанбаатар: 2006, 186

⁵⁴ I. Rachewiltz. *The Secret history of the Mongols* (Translated with a historical and philological commentary) Boston, 2004, pp 341-345

⁵⁵ Рашид-ад-Дин. *Сборник летописей*. Т.1, Книга первая. Москва, Ленинград., 1952. стр. 125

⁵⁶ Пэрлээ Х. *Их хориг хаана байна* Улаанбаатар: 1964

шинжийн харьцуулсан судалгаагаар асар том байгууламж буюу Чингис хааны булш байх боломжтой⁵⁷ хэмээх дүгнэлтэнд хүрсэн нь Х.Пэрлээ, С.Бадамхатан нарын манай ахмад судлаачдын дэвшүүлсэн таамаглал шинжлэх ухааны үндэслэлтэй болохыг нотлон харуулсан чухал алхам болсон юм. Судрын чуулган дахь “гурук” буюу “хориг”-нь ихэс, дээдсийн оршуулгын газрыг шууд нэрлэж байгааг казак, узбек зэрэг түрэг хэлт ард түмний отог, омгийн нэр хүнд бүхий хүний оршуулгын байгууламжийн гадуур босгосон “корған”, “күрғон” гэгддэг бэхлэлтийн нэр болж хадгалагдсан байдлаас харж болох ажээ (Эдүгээ эл зарчим ихэд алдагдан нэгэн омгийн төрөл төрөгсөдийн нийтийн шинжтэй болж өргөжих хандлагатай болжээ). Улмаар орос хэлнээ Өмнөд Сибирь, Дундад Азийн бүс нутгаар ихэвчлэн тархсан өндөр дараастай булш (курган)-ны нэр үг болж нэвтэрчээ⁵⁸. Иймээс “Их гурук” буюу хориг нь ихэс, дээдсээ нутаглуулсан хөл хорио бүхий ариун дагшин газар болох нь тодорхой ажээ. Харин МНТ-ны 70-р зүйл дэх “Ихэсийн газар” нь Судрын чуулганы Бурхан Халдун уулын “Их хориг”-той хэрхэн холбогдох вэ? энэ хоёр нь нэг утгатай юу, эвэл огт өөр үү?

Өмнөх судлаачид эл асуудлыг тусгайлан сонирхож байсан тухай мэдээ бидэнд одоогоор мэдэгдэхгүй байна. Бидний өмнө дурдсан зарим тайлбарлагчид “ихэсийн газар”-ыг ихэс, дээдэстээ тахилга өргөдөг газар гэж заасан боловч оршуулгын газар мөн эсэх талаар ямар нэгэн санаа хэлээгүй юм. Харин дийлэнх судлаачид дээрх хоёр сурвалж дахь “Их хориг”, “Ихэсийн газар”-ын талаарх мэдээллийг нэгтгэж, дээдсийн оршуулгын газар бөгөөд түүнд тахилга өргөдөг тусгай газар хэмээх ижил утгаар тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, XIII зууны үеийн хамгийн их чухал оршуулгын газар нь Монголын нилээд хаад ноёдыг оршуулсан Их хориг болох бөгөөд Их хориг 1227 оны үеэс бий болжээ. Онон-Хэрлэнгийн монголчуудын овог аймгийн сурвалжтаныг оршуулж, тахиглан байсан Йэкэс-эгажар (Ихсийн газар)-ыг өргөтгөн, Их хоригийг байгуулсан бололтой⁵⁹ хэмээх үзэл баримтлал юм. МНТ-дахь “Ихэсийн газар”-т тахилга үйлдэж байгаа нь түүнийг ихэс, дээдсийн оршуулгын газар гэж үзэхэд хүргэсэн ч сүүлийн жилүүдэд зарим судлаачид дээрх газруудыг тусгаар агуулгатай тайлбарлах болжээ. Тухайлбал, түүхч А.Пунсаг “Их хориг” гэдэг газар Чингис хааныг оршуулсан ба “...талийгаачийг оршуулсны

⁵⁷ Батсайхан З, Даваа Н, Бор Ж. Тэнгэрийн овоо их хааны бунхан мөн үү (Бурхан Халдуны Ихсийн газар дахь Монголын Их хаадын оршуулга). *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol. 4, №1 (312): 2008, 37-52

⁵⁸ Русско-Узбекский словарь. Москва, 1956

⁵⁹ Пэрлээ Х. *Эртний монголчуудын үхэгсэдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд*. Улаанбаатар: 1956; Пэрлээ Х. *Их хориг хаана байна*. Улаанбаатар: 1964

дараа жил бүр тогтсон хугацаанд тахилга үйлддэг бөгөөд МНТ-нд үүнийг “Ихсийн газар” (§70) хэмээн тэмдэглэсэн”⁶⁰ гэж үзэж байна. Чингис хааныг нас барсны дараа түүнд зориулан тахилга үйлддэг газрыг ийнхүү нэрлэдэг хэмээх санаа дэвшүүлсэн боловч нөгөө талаар мөнөөх “Их хориг”-ийг МНТ-нд “Ихэсийн газар” гэж тэмдэглэсэн гэж ойлгогдохоор тайлбарлажээ.

Х.Пэрлээ, С.Бадамхатан зэрэг манай ахмад судлаачид “Судрын чуулган”-ы Бурхан халдун уулаар баримжаалан Их хааны онгоныг хайсан бол Д.Базаргүр нар МНТ-ны “Ихэсийн газар”-ыг үндэслэн эрэл хайгуул хийсэн нь ихээхэн сонирхолтой судалгаа болсон юм. Судлаачид одоогийн Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Хурх голын савын Чингис (Өглөгч)-ийн хэрмийг⁶¹ МНТ-ны газар, усны нэрийн судалгаан дээр үндэслэн “Ихэсийн газар” гэж үзсэн юм. Гол үндэслэл нь “Тайчууд хавар Ихэстээ газрын тахилга өргөх үедээ Бархын голд хаваржиж байсан гэвэл Өглөгчийн хэрэм хүртэл 20 гаруй км зайтай байна. Тахилгаас орой нь буцаж ирээд маргааш өглөө нь Өэлүн эхийг хөвгүүдийн нь хамт хаяад нүүгээд явжээ. Үүнээс үзэхэд Ихэстээ газрын тахилга өргөдөг газар нь орон зай, цаг хугацааны хувьд Хэрлэн голд биш Өглөгчийн хэрэм”⁶²-нд болох явдал ажээ. Эдгээр судлаачид 2002, 2003 онд тус хэрмэнд Америкийн талтай хамтран малтлага хийсэн боловч ухмал модон австай⁶³ нэг жижиг булшнаас өөр дундад үеийн ихэс, язгууртны байж болох ганц ч оршуулга байхгүй харин халуун ханз бүхий нүхэн гэрүүд, Монголын эзэнт гүрний үеэс эрт холбогдох хэд хэдэн булш илэрсэн билээ⁶⁴. Д.Базаргүр нар ийнхүү МНТ-дахь “Ихэсийн газар”-ыг “олсноор” судлаачдын зүгээс “зарим сонирхогчид Өглөгчийн хэрмийг “Ихсийн газар буюу Их хориг” гэж үзэх (мөн л дээрх хоёр газрыг нэг мэтээр ойлгож байна С.Ө) эсхүл Чингис хааныг оршуулсан газар болгох гэж оролдож буй боловч тэр санаархал нь археологийн малтлага, Монгол

⁶⁰ Пунсаг А. *МНТ-дахь ёс заншлын судалгаа*. Улаанбаатар: 2010, 115

⁶¹ Өглөгчийн голын эхэнд орших учраас С.В.Кондратьев анх ингэж нэрлэсэн бололтой бөгөөд судалгааны хэлэнд “Өглөгчийн хэрэм” гэгдэх болжээ. Унаган нэр нь “Чингисийн хэрэм” болно, эдүгээ ч нутгийнхан ингэж нэрлэсээр авай.

⁶² Базаргүр Б., Энхбаяр Б. *Чингис хааны төрсөн ба оршуулсан газар (түүхэн газар зүйн судалгаа)*. Улаанбаатар: 2002, 24.

⁶³ Мин улсын Е Цзыцзи гэгчийн бичсэн “Цао му цзы” (авс модны тэмдэглэл)-д: Юан улсын хаадыг оршуулах ёс бол бүхэл модыг хоёр хэсэг болгож дунд нь биеийн хэмжээгээр нүхэлж нийлүүлээд авс болгодог. - Ж.Баясах. Чингис хааныг нутаглуулсан тухай хятад сурвалжийн мэдээ. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив. Хавтас 1989 он)

⁶⁴ Өлзийбаяр С. Өглөгчийн хэрэм доторхи нэгэн монгол булш. // *Археологи, Антропологи, Угсаатан судлал*. МУИС-ийн ЭШБ. 210(19). 2003, 76-81; Өлзийбаяр С. Төмөр ялтсан хуягны бүрэн олдворын тухайд. // *Угсаатан судлал*. Том. XVI, Fasc 9. 2004, 57-65; Улзибаяр С. Памятник Бурхотуйской культуры в бассейне р. Хурха. - *Древние культуры Монголии и Байкальской Сибири*. стр 290-296, Улан Уде, 2010

ба гадаадын ямар ч түүхэн сурвалжийн мэдээгээр батлагдахгүй байна”⁶⁵ гэсэн маягийн шүүмжлэлээс өөр юу ч хүртээгүй билээ. Гэвч МНТ дахь “Ихэсийн газар” болохыг тогтоох оролдлого хийсэндээрх судлаачдын түүхэн газар зүйн судалгааны үндэслэл маш сонирхолтой байна. Нүүдэлчдийн амьдралын хэв маяг, нүүдэл зүйн зарчмыг эрхбиш баримтлаваас хавар цагт хоногийн хугацаанд тайлгын ажлыг амжуулсан нь Д.Базаргүр нарын таамаглалмагадтай болохыг харуулах юм.

Археологийн судалгаагаар түрэгийн язгууртны онгоноос булш илэрсэн тохиолдол бүртгэгдээгүй нь тухайн нас барсан хүнийг тусдаа оршуулж байжээ гэж судлаачдыг дүгнэхэд хүргэсэн юм. Өөрөөр хэлбэл, улсын хаан, цэргийн эрхтэн, овог, аймгийн толгойлогч зэрэг нөлөө бүхий язгууртанд гэрэлт хөшөө, балбал бүхий тахилын сүм барьж онголон, шарилыг өөр газарт булшилдаг байж болох тухай санал юм. Ийм заншил зөвхөн түрэг төдийгүй өвөг дээдсийн шүтлэг бүхий Төв Азийн нүүдэлчдийн дунд өргөн дэлгэрч байсан нь улам тодорхой болсоор байна. Тухайлбал, Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Тавантолгой дахь хаан, хатны хөшөөт онгоноос урагш толгойн энгэрт монголын язгууртны оршуулга байгаа нь үүний илрэл болой⁶⁶. Мөн Ордосын “Чингис хааны онгон” монголчуудын дээрх зан үйлийн бас нэгэн томоохон нотолгоо билээ. Тиймээс МНТ-дахь “Ихэсийн газар”-нь онолын хувьд ургийн өвөг дээдсийн оршуулга бус онгоны газар байжээ. Чингисийн хэрэм нь Д.Базаргүр нарын таамагласнаар ургийн оршуулгатай “Ихэсийн газар” бус харин өвөг дээдэстээ тахилга үйлддэг “Ихэсийн газар” буюу онгон байх магадлал өндөр байна. Ингэж үзэх гол үндэслэл нь дээрх судлаачдын түүхэн газар зүйн судалгааны үр дүн хийгээд тус хэрмэнд хийсэн археологийн малтлага юм.

Тус хэрэм нь 3,08 км тойргийн урттай, одоо хадгалагдсан байдлаар зарим хэсэгтээ 350-380 см өндөр байгалийн чулууг засалгүй өрж хийсэн ба үүнийг Х.Пэрлээ Хятан улсын бэхлэлтийн хэрэм гэж үзжээ⁶⁷. Энэ цагаас судлаачид тус хэрмийг Кидан улсын цэргийн зориулалттай бэхлэлт хэмээн санал нэгтэй тайлбарлах болжээ⁶⁸. Гэтэл дараах үндэслэлээр тус хэрмийг цогцлоосон хугацааг

⁶⁵ Цэвээндорж Д. Монголын олон үеийн түүхийн голомт нутаг. // SA.Tom. (IY) XXIY.Fasc. 2007

⁶⁶ Өлзийбаяр С., Наваан Д., Эрдэнэ М. Сүхбаатар аймгийн нутгаар археологийн хайгуул хийсэн тухай. // *Archeology, Anthropology and Ethnology*. Vol.3. No.1(287). 2007

⁶⁷ Пэрлээ Х. *Монгол орны археологийн шинэжилгээний товч тойм*. Улаанбаатар: 1957

⁶⁸ Ивлиев А.Л. Городища Киданей. - Материалы по древней и средневековой археологии юга Дальнего Востока СССР и смежных территорий. Сб. научных трудов. Владивосток, 1983; Данилов С.В. Города в кочевых обществах Центральной Азии. Улан-Удэ, 2004, Мон-Сол төслийн 1997-1998 оны тайлан СҮМ, МҮТМ, ШУА-ийн ТХ. УБ 1999; Монгол-Японы хамтарсан “Гурван гол” экспедицийн тайлан 1991, 1992. ШУА-ийн ТХ-ийн ГБС. Энхтөр А. Монгол улсын нутаг дахь хятаны хот суурины судалгааны зарим асуудал (доктор (Ph.D) зэрэг горилох нэг сэдэвт зохиол).

судлаачдын үзэж байгаагаас урагшлуулах боломж гарч байна. Үүнд,

1. Киданы хот байгуулалтын уламжлал Өглөгчийн хэрмийнхээс илт өөр, хоорондоо ямар ч авцалдаа байхгүй байна. Киданы бэхлэлтүүд дөрвөн буландаа тэгш өнцөгт үүсгэсэн, бараг квадрат хэлбэртэй шавар, шороон хэрэм бол энд эсрэгээр байгалийн чулуугаар тодорхой хэлбэр үүсгэлгүй барьсан. Киданы бэхлэлтийн хэрмүүд нь гол усыг хамгаалалтын хэрэгсэл болгон ашигласан онцлогтой бөгөөд Х зууны эхнээс анхны хотууд баригдах болжээ⁶⁹. Гэтэл Өглөгчийн хэрэм байгалийн саад бүхий нуугдмал газрыг сонгосон нь хүчирхэг гүрний цэргийн цайз бус харин дүрвэгсэдийн бэхлэлтийг санагдуулам байна.

2. Монгол-Америкийн хамтарсан “Чингис хаан” экспедиц 2002, 2003 онд Өглөгчийн хэрмэнд 10-аад сууц малтан шинжлэхэд Алс Дорнод, Амарын сав нутгаар МЭ I мянган жилийн туршид өргөн тархаж асан халуун ханз бүхий хагас нүхэн гэрүүдтэй төслөг байгууламжууд байлаа (зураг № 2). Өглөгчийн сууцыг эртний хэлбэртэй болохыг харуулах чухал үзүүлэлт бол АНУ-ын Аризоны ИС-ийн лабораторид хийлгэсэн радиокарбоны шинжилгээний дүн юм. 6 сууцны дээжийн дийлэнх нь VII-IX зуунд холбогдох бөгөөд эдгээрээс эртнийх нь 612-682 он байна. Үүнээс “Area B” гэж дугаарлагдсан талбайн сууцны 2 дээжний дундаж үзүүлэлт (Oxcal 3.5) VII-IX зуунд холбогдож байна.

3. 2014 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн “Онон-2014” хээрийн шинжилгээний анги тус хэрмийг барьсан он цагийг тодруулах шинжилгээний шаардлага хангах дээж илрүүлэх зорилгоор чулуун ханыг дотор талаас манасан шороон овоолгын дор хэд хэдэн хэсэгт малталт хийсэн юм. Малтлагаар хэрмийн зүүн хойд хэсэг, урд хэсэг, баруун дунд хэсгүүдээс шаардлага хангах дээж илрүүлэн үүнээс 2-ыг (ch.h.d-1, ch.h.d-2) АНУ-ын ВЕТА лабораторид шинжлүүлэхэд дунджаар 780-790-ээд онд холбогдож байна. Дээрх шинжилгээнүүдээс үзэхэд хэрмийг түүн доторх сууцнуудаас ялимгүй хожуу хийсэн мэт дүгнэлтэнд хүргэж болохоор авч бидний дээж авсан шороон манаас нь хэрмийн чулуун ханыг бэхлэх үүднээс буюу түүнийг бүрэн барьж дууссаны дараа хийсэн байгууламж болох нь тодорхой юм. Тиймээс чулуун хэрэм түүн доторх хагас нүхэн гэрүүдийг харьцангуй нэг цаг үед буюу МЭ VIII зуунаас хожуугүй барьсан гэж үзэж болно.

4. 2002, 2003 онд Монгол-Америкийн хамтарсан “Чингис хаан” экспедици, 2013 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн “Онон” экспедицийн судлаачид өмнө

Улаанбаатар: 2008, 123-126

⁶⁹ Ивлиев А.Л. Городища Киданей. Материалы по древней и средневековой археологии юга Дальнего Востока СССР и смежных территорий. *Сбор. научных трудов*. Владивосток, 1983

монгол нутагт тэмдэглэгдэж байгаагүй Зүүн Өвөрбайгалын нутгаар тархсан “бурхотуй” хэмээн болзмол байдлаар нэрлэгдсэн соёлын хэд хэдэн булш малтан судалсан билээ⁷⁰.

Бурхотуйн соёлын он цагийн талаар өргөн хүрээнд буюу МЭ II-X зуунд холбогдуулан угсаатны хувьд эртний хятад сурвалжид шивэй, түрэг бичээсэнд отуз татар хэмээн бичигдсэн эртний монгол аймгуудын дурсгалд тооцдог ажээ⁷¹. Чингисийн хэрэм дотроос илэрсэн бурхотуйн соёлын хэлбэрийн булшнууд нь Онон мөрний эхэнд Бурхан халдун уулнаа ирж нутагласан Бөртэ Чино тэргүүт монгол аймгуудын үлдээсэн дурсгал бус уу хэмээх асуудал зүй ёсоор төрөн гарна. Х.Пэрлээ тэргүүтэй манай судлаачид Бөртэ Чиног 758 онд төрсөн түүхэн бодит хүн болохыг Монголын түүхийн олон сурвалжуудыг түшиглэн тогтоосон билээ (Пэрлээ:1956). Урадын мэргэн гэгээн Лувсандамбажалцаны “Алтан товч”-ийн мэдээг нягтлан Бөртэ Чинойн 29 насан дээр Батачи нэрт хөвүүн мэндэлсэн болохыг тооцоолсон судалгаа байдаг боловч МНТ-ны хажуугийн хятад товч орчуулгад Батачи ханыг 767 онд төрсөн хэмээх үгийн хадмал байдгийг Г.Мэнэс онцолжээ⁷². Гэхдээ Бурхан халдун уулнаа ирсний дараа (XVII-XVIII зууны монгол сурвалжуудад Жадын газар ирээд гэргий Гоа маралыг авсан гэж бий) энэ үйл явдал болсон нь тодорхой юм. Иймд Бөртэ чино тэргүүт нүүдэлчид 400 жилийг үдсэн Эргүнэ кунээс гараад Бурхан халдун уулнаа ирсэн үйл явдал 770-аас 780-д оноос хожуугүй бололтой⁷³. Эндээс үзэхэд Бөртэ Чинойн Бурхан халдун уулнаа ирсэн хугацаа Бурхотуйн булш бүхий Чингисийн хэрмийнхтэй үндсэндээ тохирч байна. Хожмын үр хойчис нь ихэс дээдсийн анх ирж нутагласан голомтыг дурсан санаж тахих болсон бөгөөд МНТ зохиогдох үед үүнийг “Ихэсийн газар” гэж нэрлэдэг байсан бололтой.

Ийнхүү МНТ-ны “Ихэсийн газар”- нь хожмоо дундад үеийн монгол сурвалжуудад санан дурсах утга бүхий “Жадын газар” гэж нэрлэгдэх болсон байж болох үндэслэлтэй ажээ. Дашрамд дурдахад Дармаа гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст бичиг” зохиолд “yed-un gajar”(Иэдийн газар)хэмээн бичсэн нь монгол хэлэнд олон тооны “д, с” сэлгүүцдэг тул “д”, “с” гарал язгуур нэг байж

⁷⁰ Өлзийбаяр С, Батсүрэн Б, Уртнасан Э. “Онон” хээрийн шинжилгээний ангийн тайлан. Улаанбаатар: 2013. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн баримтын сан.

⁷¹ Асеев И. В., Кириллов И. И., Ковычев Е. В. Кочевники Заб. в эпоху средневековья: (По материалам погребений). – Новосибирск.,1984., Ковычев Е. В. ИсторияЗаб. (I – сер. II тыс.н. э.): учеб. пособие. Иркутск., 1984.

⁷² Мэнэс Г. “Монголын нууц товчоон” дахь эхний хоёр мөрийн оньсого буюу “Чингис хааны язгуур” хэмээх гарчиг нэрийг нягтлах нь. // SE.Tom. XV, Fasc 8. 2003.

⁷³ Билэгт Л. Ранне монгольские племена (этногенетические изысканияна основе устной истории). Улан-батор: 2007.с.42., Батсүрэн Б. Монголын эртний улсуудын нутаг дэвсгэр. Улаанбаатар: 2003, 67.

мэдэх⁷⁴учраас “*uekes-e ġaġaru*” хэмээн бичигдэж байсан үгийг хураангуйлан олон тооны “d” дагавараар төлөөлүүлсэн үзэгдэл байж болох юм. Мөн Рашпунцагийн Болор-Эрих зохиолд монголчуудын элэнц өвөг Бөртэ-Чинойг “*yad-undalang*” (Иэдийн далан) хэмээх газар ирээд⁷⁵гэж дурдсан нь Чингисийн хэрмийг шууд заасан гэж үзүүштэй.

Бурхотуйн соёлын булш Өвөрбайгалын өмнөд нутаг Онон, Эргүнэ голын саваар хамгийн их нь 10-15, их төлөв ганцаар заримдаа 2-5 хүртэл тоотой багавтар бүлэг үүсгэсэн бол зүүн хойгуурхи нутагт 60-100 түүнээс ч их булш бүхий оршуулгын газрууд бий⁷⁶. Бурхотуйчуудын оршуулгын газар дахь булшны тооны зөрүүтэй байдал тэдний амьдралын хэв маягтай холбоотой болох нь умард нутагт суурин газрын ойролцоо том оршуулгын газрууд үлдсэн байхад өмнөд хэсгээр цөөхөн буюу нүүдэлчдийн дурсгал тархсанаас харагдаж байна. Энэ байдлыг зарим судлаачид суурин иргэд малчид болж хувирч байгаагийн жишээ болгон тайлбарлажээ⁷⁷. Бурхотуйн соёл хэмээх ерөнхий нэрийн дор хамаатуулан томъёолсон үндэслэл сул байгаа талаар бид өмнө үгүүлсэн билээ. Хойлгын малын төрөл, дагуулсан эд өлгийн зүйлс болон газар зүйн орчны байрлалаар эрс ялгарч буй учир уг соёлын эздийг өөр хооронд нь суурин ба нүүдэлчдийн гэж ялгаатай үзэх оролдлого хийж байгаа нь ч мөн учир дутагдалтай. Судлаачдын “Ононгийн хэлбэр” гэж ялган үзсэн малчдын дурсгал нь Амар хавь, Алс Дорнодоор аль эрт үеэс гахай, нохой үржүүлэн загас, ан агнуур голчлон эрхэлэн ирсэн ард түмэн нүүдэлчдийн соёлын нөлөөг хүлээн авч буй хэлбэр гэхээс илүү малчин нүүдэлчид бэлчээр бүхий уг нутагт түрэн орж ирэх болсны илрэл гэж үзэх нь үнэнд илүү дөхөх болов уу. Харин энэ хавь нутгийн суурин маягийн нөлөө тусах нь мэдээжийн хэрэг бөгөөд тэдний мал сүрэг өсөхийн хирээр шинээр бэлчээр нутаг эзэмших шаардлага урган гарах юм. Нөгөө талаар Алс Дорнод, Амар хавь, Өвөрбайгалын зүүн хэсгийн аймгуудад эрх мэдэл, эд хөрөнгийн ялгаа илт гүнзгийрч, Алс Дорнодын анхны төр улс Бохай (698-926 он) байгуулагдан хөрш зэргэлдээ аймгуудыг халдан довтлох болсон нь бусад бурхотуйн суурингуудын бэхлэлтүүдээс тод харагдаж байна. Энэ байдал нүүдэлчин “бурхотуйчууд”-дад басхүү нөлөөлөх болсон нь мэдээжийн хэрэг бөгөөд нэг талаас мохэ аймгуудын

⁷⁴ *Монгол үгсийн язгуурын толь*. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо: 1987, 2939

⁷⁵ Рашпунцаг. *Болор-Эрих* (кирилл үсгээр хөрвүүлсэн эх). Улаанбаатар: 2006, 18.

⁷⁶ Асеев И.В., Кириллов И.И., Ковычев Е.В. *Кочевники Забайкалья в эпоху средневековья* (по материалам погребений). Новосибирск, 1984 с. 22

⁷⁷ Дашибалов Б.Б. *На монголо-тюркском пограничье* (Этнокультурные процессы в Юго-Восточной Сибири в средние века) Улан-Удэ, 2005 с. 55

түрэлтээс дайжих, нөгөө талаар бэлчээр, усны эзэмшилтийн асуудал тулгарч байсан нь тодорхой юм. Ийнхүү малчин “бурхотуйчууд” Онон голыг өгсөн нүүдэллэж улмаар тэргүүн хэсэгт ирж хэрэм бэхлэлтээ байгуулан, хавь орчим нутагт мал сүргээ өсгөж, амьдран суух бололцоог олгосон бололтой байна. Тэд юун түрүүнд аюулгүй байдлаа хангах үүднээс бэхлэлтийн хэрмийг барьсан нь эдүгээ Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дахь Чингис (Өглөгчийн)-ийн хэрэм бөгөөд бидний үзэж буй “Ихэсийн газар” мөн болно.

Чингисийн хэрмэнд малтсан сууцнуудын нэгний шалан дор тусгайлан нүх ухаж, өсвөр насны эмэгтэй хүүхдийн толгойг тавиад түүний дээр ёроолоор нь тойруулан жижиг чулуунуудаар ивээс хийж өрсөн нэг том чулуугаар тагласан ихээхэн өвөрмөц зан үйл илэрчээ⁷⁸. Мэдээжийн хэрэг уг сууцанд амьдрагчид өөрсдөө бус тэдний дараа үед ийм тахилга үйлдсэн нь тодорхой юм. Дундад зууны Монголчуудад гэр дотор нь нас барагчийг оршуулдаг тухай зан үйлийн мэдээ гадаадын жуулчдын тэмдэглэлд үлджээ⁷⁹. Сурвалжийн дээрх мэдээтэй хамгийн дөхөж очих тохиолдол одоогоор чухам энэ тахилгын зан үйл билээ. Магадгүй ийм хэлбэрийн тахилга хожим монголчуудад оршуулгын зан үйл болон хувирсан эсвэл талийгаачид зориулан тусгай тахилга үйлдсэнийг оршуулгын ёслол хэмээн европ жуулчин андуурсан байж болох билээ. Мөн хэрмийн дотор баруун урд хэсэгт үхэр чулууны сэрвээн дээр зориудлан ухаж, цар мэт зүйл үйлдсэн, хэрмийн баруун хаалганаас урагш гадна хана дагуулан булан хүртэл өрсөн чулуун зам маягийн зүйл зэргийг хожим хийсэн байх бололцоотой. Эдгээр шинж тэмдгүүдийг өөрсдийн өвөг дээдэс тэртээ нутгаас нүүн ирж, шивээлэн босгосон хэрмийг ихэс, дээдсийн ариун нутаг буюу “Ихэсийн газар” гэж хүндэтгэн үзэж, МНТ-ны 70-р зүйлд тэмдэглэсэн хавар цагт тахилга үйлдэж байсны ул мөр гэж үзэж болох талтай. Мөн Юан улсын эхэн үед буюу 1257-1325 оны хооронд он цаг нь тогтоогдсон монгол оршуулга хэрмэн дотроос илэрсэн нь тухайн цагийн “Ихэсийн газар”-ын талаарх шүтлэгтэй холбогдож болох юм⁸⁰. Өөрөөр хэлбэл, Монголчуудын оршуулгын зан үйлийн газар сонгох ёсонд уулын мухар, давчуу ам бүхий Өглөгчийн хэрмийн байрлал харш бөгөөд нийтлэг жишгийг зөрчин зориудлан энд оршуулсан нь дээрхийн учиртай мэт. Эдүгээ нутгийн иргэд уул хэрмийг “Чингисийн хэрэм” гэж

⁷⁸ Өлзийбаяр С. “Чингис хаан” экспедицид 2002 онд С.Өлзийбаярын оролцсон ажлын тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан.

⁷⁹ Гэр дотор нь голомтын хавьцаа өмнө нь айрагтай хул, дүүрэн махтай цар бүхий ширээ тавьж оршуулдаг талаар П.Карпини тэмдэглэн үлдээжээ. - Плано Карпини Дж.дель. *История Монгалов*. Рубрук Г.де. Путешествие в восточные страны. Книга Марко Поло. М., 1997. с.38-39

⁸⁰ Өлзийбаяр С. Өглөгчийн хэрэм доторхи нэгэн монгол булш булш. // *Археологи, Антропологи, Угсаатан судлал*. МУИС-ийн ЭШБ. 210 (19). 2003,76-81.

нэрлэсээр байгаа нь нутгаасаа тодрон гарсан домогт хүнтэйгээ холбодог аливаа нутгийхний заншил хэмээн үзэхээс илүү язгуурын монголчуудын ихэс дээдсийн газар хэмээн онцгойлон үзэж ирсэн уламжлалтай холбох нь зүйтэй юм. Энэ нь эрт үеийн “Ихэсийн газар”-аас улбаатай өвөг дээдсийн шүтлэгийн уламжлал хадгалагдсаныг илтгэх ард олны ой санамж билээ.

Монгол сурвалжуудад Бөртэ Чинойн түүхэнд холбогдон нэр гарах өөр нэгэн газрын нэр бол Бэдийн газар болно. Үүнийг Бөртэ-Чинойн иргэдтэй ойр төрөл, эртний бэйди нарын бий болгосон монгол угсааны ард түмний сууж байсан газар гэж хэлж болох юм. Хэдийгээр энэ нутгийг нарийн тодорхойлох бололцоогүй ч гэсэн харьцангуй байдлаар Байгал, Хөвсгөлийн хоорондын нутаг байж болох юм⁸¹. Гэхдээ эртний хятадын нүүдэлчдийг нэрлэх бэй-ди хэмээх үг түвд хэлэнд бида, бэдэ гэж дуудагдах болсонтой судлаачид үндсэндээ санал нэгтэй ч түүний байсан газрыг энэ мэтээр харилцан өөрөөр заах үзэгдэл байна. МНТ-ны 88-р зүйлд “Тэмүжин ... Онон мөрөн өөд мөр мөшгив. Өрнөөс Химурга горхин орж ирэн ажгуу. Тэр өөд мөшгөөд, Химурга горхины Бэдэр хошууны Хорчухуй болдогт бүхүйд золголдов”⁸² хэмээн дурдагдсан Бэдэр гэгдэх хошуу нь өөртөө хэд хэдэн болдог агуулсан, түүний нэг нь Хорчихуй аж.Тиймээс Бэдэр нь томоохон орон зай бүхий газрын нэр болох нь мэдэгдэж буй учир бидний үгүүлэн буй Бэдэ, Бидэ улсын газрын нэр буюу гэж үзсэн судлаач бий бөгөөд Бэдэр хошууг өнөөгийн Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Биндэрьяа уулыг заасан гэж олон судлаачид үзэж байна. МНТ-ны үеийн энэ нэр хожмоо монгол түүхэн сурвалжуудад “бэдэ” хэмээн тэмдэглэгдсэн байх магадлал бас бий. Дашрамд дурдахад, Бөртэ-Чинойн ирсэн “Йэдийн газар” буюу МНТ-ны “Ихэсийн газар” болох Чингисийн хэрэм хийгээд энэхүү Биндэрьяа уулын зүүн шувтаргын хошуу хоорондоо 12 км-ийн зайтай болно. Монгол сурвалжуудад Бөртэ-Чинойн монгол нутагт анхлан суусан Жадын газар, Бэдэ улс нь хоёул дурдагдсан тохиолдолд ямагт хамт бичигдэж хоорондоо ойрхон болохыг харуулах төдийгүй нэг газрын хоёр нэр ч гэж үзэх хандлага байна. Өнөөгийн Биндэр уулын тахилга нь магадгүй дээрх сурвалжуудад Бэдэ хэмээн дурдагдах болсонтой холбогдон хуучны буюу МНТ-нд дурдагдсан Ихэсийн газрын тахилга ийнхүү Биндэрийн овооных болж хувирсан гэлтэй.

⁸¹ Коновалов П.Б. *Этнические аспекты истории Центральной Азии* (Древность и средневековье). У-У., 1999.с.121.

⁸² МНТ. Эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. Улаанбаатар: 2006

Abstract: We have to mention that we have made effort to explain the historical genesis process of Mongols in connection with Xiongnu people and the research methods and techniques have improved year by year bringing successes. However, the tendency to consider the genesis of Mongols as it is derived from Donghu people became common among the foreign researchers in the field of Xiongnu study. However, in this time we are trying to make some suggestions as the contribution to the view that who of the next generation of Xiongnu and Donghu nomads took the critical role in the genesis and culture of the Mongols. The core of the issue appeared in the period of the Jujan kingdom and the state authority was moved from Donghu generation (Mugului genesis) to Xiongnu generation. This process took place under the rule of the Tartar khan and the Xiongnu people who supported him began to be called as “Tartar”. Mongolians who were defeated by them hid in “Ergunekhun” for some period beyond the events in Asia and Europe steppe and finally they who headed by Borte-Chinoi went to the beginning of the Onon river and came to Burkhan Khaldun mountain. The first place where they made their heart place was named by their next generation as “Ikhesiingazar” and offerings have made here which were beginning of the following offering rituals to the Local God or “Ovoo”.